



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

“КОМПАНИЙН  
ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2022 оны 12-р сар

[info.gobi.mn](http://info.gobi.mn)

**АГУУЛГА**

❖ Унэлгээний аргачлал . . . . .	3
❖ Унэлгээний нэгдсэн дүн . . . . .	5
❖ Унэлгээний дэлгэрэнгүй тайлан . . . . .	6
❖ Дүгнэлт . . . . .	23
❖ Нотлох баримтын жагсаалт . . . . .	24

## ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3-р сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийн зүгээс 2022 оны 6-р сарын 9-ний өдөр үнэлгээний аргачлалыг боловсруулсан.

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-ийн ажлын алба хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулан, саналыг тусгасны үндсэн дээр ТУЗ-ийн дарга хянаж баталсан.

Мөн манай компанийн өөрийн үнэлгээний үр дүнг Монголын хөрөнгийн биржийн зүгээс хараат бусаар давхар үнэлэн, нотолгоо баримтын хамт хянан үр дүнг баталгаажуулсан болно.

### Үнэлгээний асуулгын бүтэц

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх гэсэн 9 үндсэн үзүүлэлт бүхий нийт 36 асуулгаас бүрдсэн.

### Үнэлгээний оноо

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

### Нэгдсэн үнэлгээ

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул Монголын хөрөнгийн биржээс зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Монголын хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

## ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

*Хүснэгт 1. Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн  
хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүн*

<b>№</b>	<b>Гарчиг</b>	<b>Авбал зохих оноо</b>	<b>Үнэлсэн оноо</b>	<b>Хяналтын оноо</b>	<b>Үнэлгээний хувь</b>
<b>1</b>	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	10	83.3%
<b>2</b>	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	9	90.0%
<b>3</b>	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	6	100.0%
<b>4</b>	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	6	100.0%
<b>5</b>	Эрсдэлийн удирдлага	8	8	8	100.0%
<b>6</b>	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	4	66.7%
<b>7</b>	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	6	75.0%
<b>8</b>	Компанийн соёл	6	6	6	100.0%
<b>9</b>	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	9	90.0%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>64</b>	<b>64</b>	<b>88.9%</b>

Хүснэгт 1-д үзүүлсэн нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 88.9% буюу дунд засаглалтай гэсэн үр дүнтэй гарсан байна.

## ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

*Хүснэгт 2. Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн  
хэрэгжилтийн үнэлгээний дэлгэрэнгүй тайлан*

<b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>					
<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b> <b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</b>					
<b>№</b>	<b>Зүйл</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Тайлбар</b>	<b>Оноо</b>	<b>Хувь</b>
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн 2022 оны 8-р сард шинэчлэн батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” болон “ТУЗ-ийн ажлын албаны журам”-д ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгасан. ( <a href="#">нотлох баримт 1</a> <a href="#">нотлох баримт 2</a> )	2	100%
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох процессыг КТХ-ийн дагуу зохион байгуулдаг. Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулахдаа тус хорооноос боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийн хорооны хурал дээр хэлэлцэж, нэр дэвшүүлдэг. Тус хороо нь 2022 оны сүүлийн хагас жилд ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур, ТУЗ-ийн гишүүдийн санамж бичиг, ЭБАТ-уудын залгамж халааны бодлого зэрэг баримт бичгүүдийн төслийг	1	50%

			боловсруулан, гишүүдээрээ хэлэлцсэн бөгөөд 2023 оны 1-р улиралд ТУЗ-өөр батлуулахаар төлөвлөж байна. <a href="#">(нотлох баримт 3)</a>		
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулна.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн гишүүдийг анх нэр дэвшүүлэх үед Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд гишүүдийнхээ боловсрол, ажлын туршилага, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг тусган танилцуулдаг. Харин жилийн үйл ажиллагааны тайланд гишүүдийнхээ мэргэжил, ажил, хуралдааны ирц, хувьцааны эзэмшлийн мэдээллийг товч байдлаар тусгадаг. 2022 оны жилийн тайлангаас эхлэн холбогдох мэдээллийг дэлгэрэнгүй тусган тайлагнаж, цахим хуудсандaa байршуулах болно. <a href="#">(нотлох баримт 4)</a> <a href="#">нотлох баримт 29-хавсаргав)</a>	1	50%
4	<b>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	2022 оны 8 сард “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэхдээ энэ талаар нэмэлт оруулсан болно. <a href="#">(нотлох баримт 1)</a>	2	100%
5	<b>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн	2	100%

	<b>чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</b>		үйл ажиллагаатай холбоотой чиглүүлэх танилцуулгыг хийдэг. 2023 оны 1-р улиралд багтаан ТУЗ-ийн гишүүний гарын авлагыг боловсруулах төлөвлөгөөтэй байна. Мөн Нэр дэвшигүүлэх хорооны зүгээс гишүүддээ ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох сургалтын хэрэгцээг тодорхойлон, компанийн зардлаар сургалтад хамруулдаг. <a href="#">(нотлох баримт 1)</a> <a href="#">нотлох баримт 30-хаасаргав</a> )		
6	<b>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицстой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр 2021 оны 9-р сараас эхлэн ТУЗ-ийн үйл ажиллагааг илүү сайжруулах зорилгоор ТУЗ-ийн ажлын албатай болсон бөгөөд 2022 оны 8-р сард “ТУЗ-ийн ажлын албаны журам”-г баталсан. ТУЗ-ийн ажлын албаны бүрэлдэхүүн болох ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон мэргэжилтнийг ТУЗ-өөс томилдог бөгөөд ТУЗ-ийн дарга шууд чиглүүлгээр ханган ажилладаг. <a href="#">(нотлох баримт 2)</a>	2	100%
<b>ДҮН (Авбал зохих оноо-12)</b>			10	83.3%	
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</b>					
7	<b>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь Засаглалын бодлого болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорих тухай тусгасан. Манай компани нийт 9 ТУЗ-ийн гишүүнтэйгээс 5 нь буюу олонх нь хараат бус гишүүн байдаг. Мөн ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүн томилогдон ажилладаг.	2	100%

			( <a href="#">нотлох баримт 1</a> <a href="#">нотлох баримт 5</a> нотлох баримт 31-хавсаргав)		
8	<b>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцно.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь 2016 оны 8-р сард хорооны дүрмээ шинэчлэн баталсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Эрсдэл, аудитын хороо нь улирал тутам хуралдан компанийн санхүүгийн тайлагнал, дотоод аудит, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог. ( <a href="#">нотлох баримт 10</a> нотлох баримт 32-хавсаргав)	2	100%
9	<b>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мэн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцно.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь 2017 оны 12-р сард хорооны дүрмээ шинэчлэн баталсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга томилогдон ажилладаг. Цалин урамшууллын хороо нь хагас жил тутам хуралдан компанийн цалин урамшуулал, нийгмийн халамжийн тогтолцоо, гүйцэтгэл, түүний үр дүнтэй байдал, компанийн соёлын судалгааны үр дүнд хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог. Тус хорооноос 2016 оны 12-р сард Компанийн цалин урамшууллын бодлогыг баталсан бөгөөд тус бодлогыг 2023 оны 3-р	1	50%

			улиралд багтаан шинэчлэн батлахаар төлөвлөж байна. <a href="#">(нотлох баримт 3)</a> <a href="#">(нотлох баримт 7)</a> <a href="#">(нотлох баримт 9)</a>		
10	<b>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь 2017 оны 12-р сард хорооны дүрмээ шинэчлэн баталсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Нэр дэвшүүлэх хороо нь хагас жил тутам хуралдан компанийн удирдлагын багийн ажлын тайлантай танилцан дүгнэлт өгч, компанийн ТУЗ-ийн өөрийн үнэлгээ, засаглалын үнэлгээг хэлэлцэн хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог. 2023 оны 1-р улиралд ЭБАТ-уудын залгамж халааны бодлогыг шинэчлэн батлахаар төлөвлөж байна. <a href="#">(нотлох баримт 3)</a> <a href="#">(нотлох баримт 8)</a>	2	100%
11	<b>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болох тухай ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан байдаг. Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран 2016 онд ТУЗ-ийн шийдвэрээр Аудитын хороог Эрсдэл, аудитын хороо болгон чиг үүргийн хүрээг нь илүү өргөн болгосон. <a href="#">(нотлох баримт 1)</a> <a href="#">(нотлох баримт 32-хавсаргаа)</a>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-10)				9	90.0%

**ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**  
**ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын**  
**үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана**

12	<b>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-өөс 2018 оны 7-р сард “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг анх баталсан. СЗХ-ноос шинээр баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу тус журамдаа холбогдох сайжруулалтыг хийн “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам” нэртэйгээр 2022 оны 11-р сард шинэчлэн баталсан. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган олон нийтэд хүргэх хугацаат болон тухай бүр мэдээлэх мэдээллийг МХБ болон компанийн цахим хуудас ( <a href="mailto:info.gobi.mn">info.gobi.mn</a> )-аар дамжуулан тогтмол мэдээлдэг ба хэрэгжилтэд ТУЗ хяналт тавин ажилладаг. ( <a href="#">нотлох баримт 10</a> )	2	100%
13	<b>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааерыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн цахим хуудсанд хувьцаа эзэмшигч, олон нийтэд зориулан компанийн санхүү, үйл ажиллагаа болон засаглалтай холбоотой мэдээ мэдээллүүд (санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, засаглалын үнэлгээний үр дүн, бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагаатай холбоотой шинэ мэдээ, мэдэгдэл гэх мэт)-ийг байршуулан, тогтмол шинэчлэн ажилладаг. Мөн цахим хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигч нараас санал хүсэлтийг нь хүлээн авч, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан ажиллахыг зорьдог. ( <a href="#">нотлох баримт 11</a> <a href="#">нотлох баримт 12</a> )	2	100%
14	<b>3.3. Санхүүгийн болон санхүүгийн</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн ТУЗ болон удирдлагын баг нь компанийн	2	100%

	<p><b>бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</b></p>	<p>үйл ажиллагааны тайлангийн агуулгаа жил бүр сайжруулан ажилладаг. Бид санхүүгийн тоон үзүүлэлтийг хүн бүрт ойлгомжтой байлгах зорилгоор нэмэлт график, тайлбартай оруулахаас гадна хөндлөнгийн аудитын дүгнэлт, тодруулгыг бүрэн эхээр нь хавсарган оруулж санхүүгийн ил тод байдлыг хангадаг.</p> <p>Харин санхүүгийн бус тайлагналын хувьд борлуулалтын зах зээл тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, үйлдвэрлэл дизайн, бүтээгдэхүүн хөгжүүлэлт гэх мэт компанийн үйл ажиллагааны үр дүн, байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил зэрэг агуулгаар мэдээлэл бэлтгэн оруулдаг.</p> <p>Мөн эдгээр мэдээллүүдийг Говь ХК-ийн цахим хуудсанд нээлттэй байдлаар байршуулан тогтмол шинэчилдэг ба цаашид тайлангийн агуулгаа тасралтгүй сайжруулан ажиллана.</p> <p>(<a href="#">нотлох баримт 4</a> <a href="#">нотлох баримт 13</a>)</p>	
	ДҮН (Авбал зохих оноо-6)	6	100.0%

**ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО****ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана**

15	<p><b>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Эрсдэл, аудитын хорооны дүрмийн 4.1-д хөндлөнгийн аудиторт тавигдах хараат бус байдал болон бусад шалгуур үзүүлэлтийг тогтоох, эрх үүрэг, хариуцлага, төлбөрийн хэмжээ зэрэг бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр	2	100%
----	--	---------------------	---	---	------

	<b>боловжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>		хэлэлцүүлэн батлуулахаар тусгасан байдаг. Тус хорооны зүгээс 2016 оны 10-р сард “Хараат бус аудитын компанийд тавигдах шаардлага”-ыг боловсруулан баталсан. Мөн ТУЗ-өөс 2021 оны 9-р сард “Хөндлөнгийн аудит томилох журам”-ыг баталсан. Эрсдэл, аудитын хороо нь дээрх дүрэм, тогтоолуудын хэрэгжилтийг хангахаас гадна жил бүр хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавин, оны эхний хурал дээрээ хараат бус аудиторын дүгнэлт, тайланг хэлэлцэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах тал дээр компанийн удирдлагуудад үүрэг даалгавар өгөн хяналт тавьж ажилладаг. ( <a href="#">нотлох баримт 6</a> <a href="#">нотлох баримт 14</a> нотлох баримт 33-хаесаргав)		
16	<b>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Жил бүр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр хөндлөнгийн аудитын байгууллагаас төлөөллийг биечлэн оролцуулж, хувьцаа эзэмшигч нарыг хөндлөнгийн аудитораас асуулт асууж, мэдээлэл авах боломжоор ханган ажилладаг. ( <a href="#">нотлох баримт 34-хаесаргав</a> )	2	100%
17	<b>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Эрсдэл, аудитын хорооны шууд харьялалд Дотоод аудитын хэлтэс ажилладаг. Жилийн үйл ажиллагааны тайланд дотоод аудитын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг мэдээллийг тусгадаг.	2	100%

	<b>компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</b>		Мөн жилийн эцэст Дотоод аудитын хэлтсийн зүгээс компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлага болон засаглалын тогтолцооны гурвалсан үнэлгээг хийн, үр дүнг нь хорооны хурлаар хэлэлцэн дүгнэлт өгдөг. Цаашид компанийн зүгээс дотоод хяналтын тогтолцоог тасралтгүй сайжруулах тал дээр анхааран ажиллана. <a href="#">(нотлох баримт 4)</a> <a href="#">(нотлох баримт 15)</a>		
ДҮН (Авбал зохих оноо-6)		6	100.0%		

**ТАБ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

**ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина**

18	<b>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтээцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Эрсдэл, аудитын хороо нь 2016 оны 6-р сард компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд Эрсдэлийн удирдлагын багийг томилж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх процессын зураглалыг баталж байсан. Мөн Эрсдэл, аудитын хорооноос “Эрсдэлийн удирдлагын бодлого”, Гүйцэтгэх захирлын тушаалаар “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг тус тус баталж, хэрэгжилтийг нь хангуулан, улирал бүрийн хурал дээрээ хяналт тавин ажилладаг бөгөөд үр дүнг нь ТУЗ-ийн хурал дээр танилцуулдаг. <a href="#">(нотлох баримт 6)</a> <a href="#">(нотлох баримт 16)</a>	2	100%
19	<b>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-өөс компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2016 онд Аудитын хорооны чиг үүрэг дээр эрсдэлийн удирдлагыг	2	100%

	<p><i>зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i></p>		<p>хариуцах чиг үүргийг нэмэгдүүлэн Эрсдэл, аудитын хороо болгосон. Тус хороо нь З гишүүнтэйгээс 2 нь хараат бус гишүүн бөгөөд, хорооны даргаар мөн хараат бус гишүүн томилогдон ажилладаг.</p> <p>Эрсдэл, аудитын хороо нь улирал бүрийнхээ хурлаар компанийн эрсдэлийн удирдлагын багийн тайлантай танилцаж, компанийн хэмжээнд учирч болох эрсдэл болон түүнд авах хариу арга хэмжээний талаар хэлэлцэн, чиглүүлэг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг.</p> <p>Жилийн үйл ажиллагааны тайландаа тус хорооны бүтэц бүрэлдэхүүн, ажлын тайлангаас гадна компанийн эрсдэлийн удирдлагын талаар мэдээ мэдээллийг тусган тайлагнадаг.</p> <p>(<a href="#">нотлох баримт 4</a> <a href="#">нотлох баримт 6</a>)</p>		
20	<p><b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Говь ХК-ийн ТУЗ-өөс 2022 онд Тогтвортой хөгжлийн үүрэг амлалтыг баталсан. Мөн Гүйцэтгэх захирлын тушаалаар Тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлон баталсан. Бид жилийн үйл ажиллагааны тайландаа Тогтвортой хөгжил гэсэн бүлгийн хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагаатай холбоотой тайланг дэлгэрэнгүй тусган оруулдаг.</p> <p>Мөн 2022 оны 4-р сард МХБ-ээс боловсруулсан БОНЗ-ын тайлангийн маягтын дагуу анх удаа үнэлгээ хийн тайлан бэлтгэсэн бөгөөд тус тайлангаа МХБ-д хүргүүлэн, компанийн цахим хуудсаар</p>	2	100%

			дамжуулан олон нийтэд мэдээлсэн. ( <a href="#">нотлох баримт 4</a> <a href="#">нотлох баримт 17</a> <a href="#">нотлох баримт 18</a> <a href="#">нотлох баримт 19</a> )		
21	<b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь байгууллагын дагаж мөрдөх шаардлагауд болон бусад үүрэг амлалтын нийцлийг удирдах замаар байгууллагын соёл, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх, компанийн хэмжээнд комплаенсын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор 2021 оны 11-р сараас эхлэн Тогтвортой хөгжлийн хэлтсийн харьялалд Комплаенсын нэгжийг үүсгэн, Комплаенсын менежертэй болсон. 2022 оны 4-р сард Комплаенсын бодлогыг боловсруулан баталсан бөгөөд цаашид шат дараатай хяналтыг хэрэгжүүлэн тасралтгүй сайжруулалт хийн ажиллахаар төлөвлөж байна. ( <a href="#">нотлох баримт 20</a> )	2	100%
<b>ДҮН (Авбал зохих оноо-8)</b>				8	100.0%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> <b>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</b>					
22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь ТУЗ-ийн гишүүдийнхээ цалин урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэн баталж, мөрдөн ажилладаг. Хамгийн сүүлд 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалинг хэлэлцэн баталсан бөгөөд энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ( <a href="#">нотлох баримт 35-хавсаргав</a> )	2	100%

23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Цалин, урамшууллын хороо нь 2016 оны 12-р сард “Цалин урамшууллын бодлого”-ыг баталсан. Компанийн хэмжээнд 2022 оны 3-р сараас эхлэн Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог шинэчлэн сайжруулах ажил шат дараатай хийгдэж байгаа бөгөөд 2023 онд тус бодлогыг шинэчлэн батлахаар төлөвлөж байна. <a href="#">(нотлох баримт 3)</a> <a href="#">(нотлох баримт 9)</a>	2	100%
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайландаа гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>	Хэрэгжүүлээгүй.	Жилийн үйл ажиллагааны тайландаа Гүйцэтгэх удирдлагын багийн цалин урамшууллын хэмжээг багцалсан дүнгээр, харин эзэмшиж буй хувьцааны мэдээллийг нь хүн тус бүрээр задаргаатай тусгадаг. Цаашид Гүйцэтгэх удирдлагын багийнхны цалин урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийг илүү дэлгэрэнгүй тусгадаг болох дээр анхааран ажиллана. <a href="#">(нотлох баримт 4)</a>	0	0%
<b>ДҮН (Авбал зохих оноо-6)</b>				4	66.7%

**ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ****Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ**

25	<b>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь үйл ажиллагаандaa бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хангах тал дээр анхааран ажилладаг бөгөөд энэ талаар Засаглалын бодлого болон Ёс зүйн коддоо тусгасан байдаг. ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын дагуу 2018 оны 12-р сард Гүйцэтгэх захирлын тушаалаар “Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах шийдвэрлэх журам”-ыг анх баталсан бөгөөд 2022 оны	2	100%
----	---	---------------------	---	---	------

	<b>байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</b>		10-р сард тус журмаа шинэчлэн, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Цаашид оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг боловсруулахаар төлөвлөж байна. <a href="#">(нотлох баримт 3)</a> <a href="#">(нотлох баримт 5)</a> <a href="#">(нотлох баримт 21)</a> <a href="#">(нотлох баримт 22)</a>		
26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</b>	Хэрэгжүүлээгүй.	Жилийн үйл ажиллагааны тайландаа хувьцаа эзэмшигч, харилцагч болон олон нийт гэх мэт бүхий л оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцэхүйц агуулгаар санхүүгийн болон санхүүгийн бус мэдээ мэдээллийг тусган, жил бүр агуулгаа сайжруулдаг. <a href="#">(нотлох баримт 4)</a>	0	0%
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн цахим хуудсанд хувьцаа эзэмшигч нар болон олон нийтэд зориулсан компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг нийтлэн, агуулгыг нь тогтмол шинэчлэн ажилладаг. Мөн оролцогч талуудтай хамтран ажиллах саналыг зарлах, тэдгээрээс санал хүсэлт хүлээн авах цэстэй бөгөөд санал хүсэлтийг нь тогтмол хүлээн авч эргэх холбоотой ажилладаг. <a href="#">(нотлох баримт 12)</a> <a href="#">(нотлох баримт 26)</a>	2	100%
28	<b>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	“Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах шийдвэрлэх журам”-д ажилтнуудаас ирсэн санал гомдлыг хэрхэн хүлээн авч, шийдвэрлэх талаар тусгасан байдаг. Мөн ажилтнуудаа сургаж хөгжүүлэн мэргэжил	2	100%

	<b>дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</b>		дээшлүүлэх асуудлыг “Сургалт хөгжлийн журам”-аар зохицуулдаг бөгөөд жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилладаг. Ажилтнуудын нийгмийн асуудлыг үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын гэрээний дагуу шийдвэрлэн, хэрэгжилтийн тайлангаар дүгнэн сайжруулалт хийдэг. <a href="#">(нотлох баримт 21)</a> <a href="#">нотлох баримт 36-хавсаргав</a>		
<b>ДҮН (Авбал зохих оноо-8)</b>			<b>6</b>	<b>75.0%</b>	

**НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ**

**ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно**

29	<b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-өөс 2022 оны 8-р сард “Ёс зүйн код”-ыг шинэчлэн баталсан бөгөөд компанийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Энэхүү “Ёс зүйн код”-д компанийн ёс зүйн зарчим болон ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, нийт ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхой тусгасан байдаг. <a href="#">(нотлох баримт 22)</a>	2	100%
30	<b>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь 2022 оны 11-р сараас эхлэн Ёс зүйн хороогоор дамжуулан компанийн хэмжээнд илэрсэн ёс зүйн зөрчлийг хүлээн авч, шийдвэрлэх, хяналтыг хэрэгжүүлэх зорилготой “Шүгэл үлээгчийн тогтолцоо”-г хэрэгжүүлэн ажиллаж байна. <a href="#">(нотлох баримт 23)</a> <a href="#">нотлох баримт 24)</a>	2	100%
31	<b>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь 2022 оны 8 сард баталсан “Ёс зүйн код”-доо ашиг сонирхлын зөрчил, авлига, хээл хахуулиас ангид	2	100%

	<b>ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</b>		хуулийн хурээнд ажиллах тухай болон засгийн газар, улс төр, шашны харилцааны талаар баримтлах зарчмуудыг тусган оруулсан байдаг. Энэхүү зарчмуудынхаа дагуу авлига албан тушаалын зөрчлөөс сэргийлэх, хандив, бэлэг дурсгал өгөх болон хүлээн авах талаарх зохицуулалтыг хийдэг. Мөн ТУЗ-өөс 2021 оны 9-р сард “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг баталсан. ( <a href="#">нотлох баримт 22</a> <a href="#">нотлох баримт 25</a> )		
--	--	--	--	--	--

ДҮН (Авбал зохих оноо-6)

6

100.0%

**ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ**

**Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана**

32	<b>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ынхаа хэрэгжилтийг ханган оролцогч талуудад хүргэх хугацаат болон тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг МХБ болон компанийн цахим хуудсаар дамжуулан хугацаанд нь мэдээлдэг. Бид 2021 оны 7-р сард компанийн цахим хуудасны бүтэц, агуулгын цар хүрээгээ шинэчлэн оролцогч талуудад компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл, бодлого журмуудаа нээлттэйгээр мэдээлэн ажиллаж байна. ( <a href="#">нотлох баримт 10</a> <a href="#">нотлох баримт 26</a> )	2	100%
33	<b>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг албан ёсоор батлаагүй боловч “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ынхаа хэрэгжилтийг	1	50%

	<b>харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</b>		ханган цахим хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа компанийн тухай мэдээ мэдээллийг тухай бүр хүргэхээс гадна санал хүсэлтийг нь нээлттэй хүлээн авч, шийдвэрлэн, хариу өгч ажилладаг. Бид цаашид гадаад хөрөнгө оруулагч болон харилцагчдынхаа эрх ашгийг улам бүр хангахыг зорин компанийн цахим хуудас дахь мэдээллээ англи хэл дээр давхар хүргэдэг болохоор зорилт тавин ажиллаж байгаа. <a href="#">(нотлох баримт 12)</a> <a href="#">(нотлох баримт 26)</a>		
34	<b>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн ТУЗ-өөс 2018 оны 4-р сард “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг анх баталсан бөгөөд 2021 оны 4-р сард тус журмаа шинэчлэн баталж, хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах агуулгыг нэмсэн. Энэхүү журмаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хуралд оролцох, санал өгөх зэрэг эрхээ хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигч нарт хурлын зарыг хүргэх, ХЭХ-ыг зохион байгуулахтай холбоотой бүхий л харилцааг зохицуулсан байдаг ба хэрэгжилтийг нь ханган ажилладаг. <a href="#">(нотлох баримт 27)</a>	2	100%
35	<b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хүндэтгэн, Компанийн тухай хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх боломжоор нь хангахад анхаарч, аливаа шийдвэрийг гаргахдаа	2	100%

	<b>онцгойлон анхаарна.</b>		засаглалын сайн зарчмыг баримтлан ажилладаг. ( <a href="#">нотлох баримт 12</a> )		
36	<b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь жил бүрийн эхний ТУЗ-ийн хурал дээрээ тухайн жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл болон гүйлгээ хийх холбоотой талын компаниудын нэрсийг баталж, жилийн эцэст тогтоолынхоо хэрэгжилтийг хянан тухайн онд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй танилцан, хяналт тавьдаг. Мөн жилийн үйл ажиллагааны тайланда холбоотой талуудтай хийгдсэн сонирхлын зөрчилтэй гүйлгээний талаарх тайлан болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээллийг нийтэлж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр Эрсдэл, аудитын хорооны зүгээс гүйцэтгэлийг нь танилцуулдаг. ( <a href="#">нотлох баримт 4</a> <a href="#">нотлох баримт 28</a> )	2	100%
<b>ДҮН (Авбал зохих оноо-10)</b>				9	90.0%
<b>НЭГДСЭН ДҮН (Авбал зохих оноо-72)</b>				64	88.9%

## ДҮГНЭЛТ

Говь ХК нь олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.

2022 онд шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд 88.9% буюу дунд засаглалтай гэсэн үр дүнтэй гарлаа. Энэ нь бидэнд анхаарч сайжруулах зүйлсээ олж харах боломжийг олгож байгаа бөгөөд бид энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Бодлого журмыг шинэчлэн сайжруулахтай холбоотой:

- ❖ ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг батлах;
- ❖ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлтийг шинэчлэх;
- ❖ ЭБАТ-уудын залгамж халааны бодлогыг батлах;
- ❖ Компанийн цалин урамшууллын бодлогыг шинэчлэх;
- ❖ ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмыг шинэчлэх;
- ❖ Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг батлах; ба
- ❖ Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлоготой болох.

Жилийн үйл ажиллагааны тайлангийн агуулгыг сайжруулахтай холбоотой:

- ❖ ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулдаг болох;
- ❖ Гүйцэтгэх удирдлагын багийнхны цалин урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийг илүү дэлгэрэнгүй тусгадаг болох; ба
- ❖ Оролцогч талуудтай холбоотой мэдээллийн агуулгыг нэмэлтээр оруулдаг болох.

Үйл ажиллагаагаа сайжруулахтай холбоотой:

- ❖ Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй болох; ба
- ❖ Компанийн цахим хуудас дахь мэдээллийг давхар англи хэл дээр хүргэдэг болох.

## НОТЛОХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

### Линкээр оруулсан нотлох баримтууд

1. [ТУЗ-ийн үйл ажиллагааны журам](#)
2. [ТУЗ-ийн ажлын албаны журам](#)
3. [Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр](#)
4. [2021 оны Жилийн үйл ажиллагааны тайлан](#)
5. [Засаглалын бодлого](#)
6. [Эрсдэл, аудитын хорооны дүрэм](#)
7. [Цалин урамшууллын хорооны дүрэм](#)
8. [Нэр дэвшүүлэх хорооны дүрэм](#)
9. [Цалин урамшууллын бодлого](#)
10. [Олон нийтэд мэдээлэл хүргэх журам](#)
11. [Компанийн цахим хуудсанд байршиулсан засаглалын дүрэм, журмууд](#)
12. [Компанийн цахим хуудас дахь санал хүсэлтийн булан](#)
13. [Компанийн цахим хуудсанд байршиулсан тайлангууд](#)
14. [Хөндлөнгийн аудит томилох журам](#)
15. [Дотоод хяналтын бодлого](#)
16. [Эрсдэлийн удирдлагын бодлого](#)
17. [Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт](#)
18. [Тогтвортой хөгжлийн бодлого](#)
19. [БОНЗ-ын тайлан](#)
20. [Комплаенсын бодлого](#)
21. [Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах шийдвэрлэх журам](#)
22. [Ёс зүйн код](#)
23. [Шугэл үлээгчийн тогтолцооны үйл ажиллагааны журам](#)
24. [Компанийн цахим хуудас дахь шугэл үлээх систем](#)
25. [Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам](#)
26. [Компанийн албан ёсны цахим хуудас /info.gobi.mn/](#)
27. [Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам](#)
28. [2022 онд сонирхлын зөрчил бухий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн тогтоол](#)

**Хавсаргасан нотлох баримтууд**

29. 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын материал
30. ТУЗ-ийн шинэ гишүүдийг анх томилогоход хамруулдаг чиглүүлэх сургалтын материал
31. 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг томилсон тухай тогтоол
32. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталсан тухай тогтоол
33. Хараат бус аудиторт тавигдах шаардлага
34. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл
35. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчилсэн тогтоол
36. Сургалт хөгжлийн журам

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

М.Сэлэнгэ

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:

ТУЗ-ийн дарга

Д.Гэрэлмаа

2022 оны 12-р сар

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул  
дүүрэг, Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081  
И-мэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn)